

ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



70

АУДИТЫН ТАЙЛАН

Орхон аймгийн Засаг даргын 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд  
хийсэн аудитын тайлан

Аудитын код: ОРА-2024/01/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: <a href="mailto:narmandakhts@audit.gov.mn">narmandakhts@audit.gov.mn</a>
Эрдэнэт хот 2023 он	Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: <a href="mailto:buyanundrakhb@audit.gov.mn">buyanundrakhb@audit.gov.mn</a>
	Ахлах аудитор: Т.Болормаа Утас: 70355805 Цахим хаяг: <a href="mailto:bolormaat@audit.gov.mn">bolormaat@audit.gov.mn</a>
	Аудитор: О.Гантуяа, Г.Даваасүрэн Утас: 70355805 Цахим хаяг: <a href="mailto:gantuyao@audit.gov.mn">gantuyao@audit.gov.mn</a> <a href="mailto:davaasureng@audit.gov.mn">davaasureng@audit.gov.mn</a>

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ОРХОН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар А/02

Эрдэнэт

Аудитын тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 20 дугаар зүйлийн 20.1, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2023 оны А/102 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх"-ийн 1.4, 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Орхон аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл"-д хийсэн аудитын тайлан /ОРА-2024/01/НА-СТА-ТЭЗ/-г баталгаажуулсугай.

2. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн нэгтгэлд орсон "Төсвийн захирагчид, орон нутгийн өмчит газрууд"-ын 2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг нэгдүгээр хавсралтаар, тогтоосон төлбөрийн актын жагсаалтыг хоёрдугаар хавсралтаар, зөрчлийн албан шаардлагын жагсаалтыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хангуулж, аймгийн хэмжээнд нэгтгэн, үр дүнгийн талаар 2024 оны 11 сарын 30-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт хариу ирүүлэхийг аймгийн Засаг даргын орлогч /М.Түмэнжаргал/, аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Ш.Ганболд нарт даалгасугай.

4. Аудитын тайланг Үндэсний аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад хүргүүлж, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер /Б.Буян-Ундрах/, ахлах аудитор /Л.Болормаа, Г.Оргилмөрөн, В.Жавзмаа/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

D:\my doc\bichig heregl tushaal\2024.doc

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын  
дарга, тэргүүлэх аудиторын 2024 оны 04  
дүгээр сарын 19-ний өдрийн А/02 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт

Аудитын тайлангийн жагсаалт

№	Байгууллагын нэр	Аудитын код	Дүгнэлт
1	Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	ОРА-2024/35/НА-СТА-ТШЗ	Өөрчлөлтгүй
2	Орхон аймгийн засаг даргын тамгын газар	ОРА-2024/36/НА-СТА-ТШЗ	Өөрчлөлтгүй
3	Эрдэнэт хотын захирагчийн алба	ОРА-2024/27/НА-СТА-ТШЗ	Өөрчлөлтгүй
4	Орхон аймгийн Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	ОРА-2024/48/НА-СТА-ТШЗ	Өөрчлөлтгүй
5	Орхон аймгийн Баян-Өндөр сумын Засаг даргын тамгын газар	ОРА-2024/50/НА-СТА-ТШЗ	Өөрчлөлтгүй
6	Орхон аймгийн Жаргалант сумын Засаг дарга	ОРА-2024/01/НА-СТА-ТТЗ	Өөрчлөлтгүй
7	Орхон аймгийн Жаргалант сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	ОРА-2024/44/НА-СТА-ТШЗ	Өөрчлөлтгүй
8	Орхон аймгийн Жаргалант сумын Засаг даргын тамгын газар	ОРА-2024/46/НА-СТА-ТШЗ	Өөрчлөлтгүй
9	Орхон аймгийн Хот тохижуулах газар	ОРА-2024/38/НА-СТА-ТШЗ	Хязгаарлалттай
10	Орхон аймгийн орон нутгийн өмчийн газар	ОРА-2024/32/НА-СТА-ТШЗ	Өөрчлөлтгүй
11	Орхон аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	ОРА-2024/51/НА-СТА-ТШЗ	Өөрчлөлтгүй
12	Орхон аймгийн Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн газар	ОРА-2024/37/НА-СТА-ТШЗ	Өөрчлөлтгүй
13	Орхон аймгийн Нийтлэг үйлчилгээний алба	ОРА-2024/34/НА-СТА-ТШЗ	Өөрчлөлтгүй
14	Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ ОНӨХК	ОРА-2024/05/НА-СТА-ОНА	Өөрчлөлтгүй
15	Мэдээлэл шуурхай удирдлагын төв	ОРА-2024/57/НА-СТА-ТШЗ	Өөрчлөлтгүй
16	Орхон аймгийн Хот байгуулалт барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ	ОРА-2024/06/НА-СТА-ОНА	Хязгаарлалттай
17	"Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргаа" УТҮГ	ОРА-2024/04/НА-СТА-ОНА	Өөрчлөлтгүй
18	Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ	ОРА-2024/03/НА-СТА-ОНА	Сөрөг
19	Амралт аялал жуулчлалын Их шүтээн цогцолбор	ОРА-2024/08/НА-СТА-ОНА	Хязгаарлалттай
20	"Гэр бүлийн ордон" ОНӨААТҮГ	ОРА-2024/07/НА-СТА-ОНА	Өөрчлөлтгүй
21	Жаргалант ус дулаан түгээх станц ОНӨХК	ОРА-2024/09/НА-СТА-ОНА	Өөрчлөлтгүй

## ТОВЬЁГ

Товчилсон үгийн тайлбар .....	7
Хүснэгтийн товьёг.....	8
<b>АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ.....</b>	<b>9</b>
<b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: .....</b>	<b>9</b>
<b>Аудитын зорилт: .....</b>	<b>9</b>
<b>Аудитын хамарсан хүрээ: .....</b>	<b>9</b>
<b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт: .....</b>	<b>9</b>
<b>Аудитын бүрэлдэхүүн, хугацаа: .....</b>	<b>10</b>
<b>БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТАТВАРЫН ОРЛОГО ДАВЖ БИЕЛЭСЭН БОЛ ТАТВАРЫН БУС ОРЛОГО ТАСАРСАН БАЙНА.....</b>	<b>11</b>
1.1 Орон нутгийн төсвийн орлогыг 2 удаа тодотгож 36,615.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн татварын орлогод төвлөрөх ёстой орлого Эрдэнэт сангийн орлогоор төлөвлөгдөж байна. ....	11
1.2 Төсвийн орлого нийт дүнгээрээ 2.6 хувиар давж биелсэн ч татварын бус орлогын төлөвлөгөө 29 хувиар тасарсан байна.....	12
1.3 Аймгийн татварын бус орлогын төлөвлөгөө 71 хувь буюу 12,140.9 сая төгрөгөөр тасарсан байна.....	14
<b>БҮЛЭГ 2: ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ СУЛ ДУТМАГААС ХЭТ ӨНДӨР ХЭМНЭЛТ ҮҮСЭХ ЭРСДЭЛ НЭМЭГДСЭН БАЙНА. ....</b>	<b>15</b>
2.1 Төсвийн зарлагыг бодитой төлөвлөөгүйгээс хэт өндөр хэмнэлт үүсэх, төсвийн зарцуулалтыг байгууллага бүртэй тооцоо нийлж акт үйлдээгүй нь хяналт дутмаг байгааг харуулж байна. ....	15
2.1 Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.....	18
<b>БҮЛЭГ 3. ЗАСАГ ДАРГЫН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ 91.7 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА. ....</b>	<b>19</b>
3.1 Аймгийн 2023 оны худалдан авах ажиллагаанаас 6,325.7 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна. ....	19
3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, арга, хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл өмнөх оноос 2.21 хувиар өссөн ч хөрөнгө оруулалтын гүйцэтгэл өмнөх оноос 15 хувиар буурсан байна. ....	21
<b>БҮЛЭГ 4. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААДЫН ЗЭЭЛЭЭР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ОН ДАМЖИН ХЭРЭГЖСЭЭР БАЙНА.....</b>	<b>23</b>
4.1 Орон нутагт зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөг сайжруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна. ....	23
4.2 Өмнөх оны Засаг даргын нэгтгэсэн тайлангийн нэгдсэн гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.....	23
Аудитын дүгнэлтүүд: .....	24
<b>Зөвлөмж .....</b>	<b>24</b>

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТБӨЯХАТ	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТТАМНАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ХО	Хөрөнгө оруулалт
ТБОНӨБХБ	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсан
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ДТС	Дулаан түгээх сүлжээ
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ЗСБҮА	Зөвлөх сонгох бага үнийн арга
ОНОХА	Олон нийтийн оролцоог хангах арга
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани
БХБНАА	Барилга хот байгуулалтын нийтийн аж ахуй

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Орхон аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, улсын төсөвт төвлөрүүлэх орлого	7
Хүснэгт 3	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт	7
Хүснэгт 3	Эрдэнэт сангийн орлогын төлөвлөлт	8
Хүснэгт 4	Орон нутгийн татварын орлогын биелэлт	8
Хүснэгт 5	Орон нутгийн татварын бус орлогын биелэлт	10
Хүснэгт 6	Орон нутгийн төсвийн зардал, тодотгол /Аймаг/	11
Хүснэгт 7	Орон нутгийн төсвийн зардал, тодотгол /Баян-өндөр сум/	11
Хүснэгт 8	Орон нутгийн төсвийн зардал, тодотгол /Жаргалант сум/	11
Хүснэгт 9	Орон нутгийн төсвийн зардлын гүйцэтгэл	12
Хүснэгт 10	Улсын төсвийн захиргааны байгууллагын албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл	13
Хүснэгт 11	Нэмэлт санхүүжилтийн орлогын судалгаа	14
Хүснэгт 12	Нэмэлт санхүүжилтийн зардлын гүйцэтгэл	15
Хүснэгт 13	Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөлт /аймаг/	15
Хүснэгт 14	Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөлт /Баян-өндөр сум/	16
Хүснэгт 15	Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөлт /Жаргалант сум/	16
Хүснэгт 16	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл	16
Хүснэгт 17	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам, арга хэмжээ	17
Хүснэгт 18	Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл	17

## АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

### Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4 дэх заалт, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2023 оны “Аудитын сэдэв батлах тухай” 08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/162 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2024 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

### Аудитын зорилт:

Орхон аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхийг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан, дүнг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад танилцуулахад аудитын зорилт чиглэсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

- Аймгийн 2023 оны төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл
- 2023 оны худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэл
- Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, үр дүн
- Нэмэлт төсвийн гүйцэтгэл
- Засгийн газрын өр болон Засгийн газрын өрийн баталгааны мэдээлэл

### Аудитын хамарсан хүрээ:

Аудитыг аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Сангийн яамнаас Орхон аймгийн 2023 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянасан дүн, тооцоолол, аймгийн Татварын хэлтсийн дүн, мэдээ зэрэг баримт материалд тулгуурлан гүйцэтгэлээ.

### Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, аудитыг чиглүүлж гаргасан бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно.

Аудитад дараах хууль эрхийн актыг шалгуур үзүүлэлтийн эх сурвалж болгон ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Үндсэн хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төрийн аудитын тухай хууль,
- Монгол улсын 2023 оны төсвийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Татварын багц хуулиуд,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолууд,
- Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2021 оны “Ерөнхий чиглэл, аргачилсан зөвлөмж батлах тухай” А/111 дүгээр тушаал
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт, стандарт

**Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:**

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Буян-Ундрах үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Т.Болормаа, аудитор О.Гантуяа, Г.Даваасүрэн 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2024 оны 04 дүгээр сарын 19-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.



**БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТАТВАРЫН ОРЛОГО ДАВЖ БИЕЛЭСЭН БОЛ ТАТВАРЫН БУС ОРЛОГО ТАСАРСАН БАЙНА.**

1.1 Орон нутгийн төсвийн орлогыг 2 удаа тодотгож 36,615.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн татварын орлогод төвлөрөх ёстой орлого Эрдэнэт сангийн орлогоор төлөвлөгдөж байна.

Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 17 дугаар зүйлд 2023 оны төсвийн жилд Орхон аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 164,107.3 сая төгрөгөөр, 18 дугаар зүйлд орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийг 16,970.4 сая төгрөгөөр тус тус баталсан байна.

Өмнөх онтой харьцуулахад орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг болон улсын төсөвт төвлөрүүлэх орлого өссөн байна.

*Хүснэгт №1 Орхон аймгийн орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг, улсын төсөвт төвлөрүүлэх орлого /сая төгрөг/*

№	Орлогын эх үүсвэр	2022 он	2023 он	Зөрүү
1	Орон нутгийн хөгжлийн санд олгох шилжүүлэг	9,915.5	16,970.4	7,054.9
2	Төвлөрүүлэх орлого	91,010.6	164,107.3	73,096.7

Аймгийн ИТХ-ын 2022 оны 12 дүгээр сарын 02-ны өдрийн 13/09 дүгээр тогтоолоор улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 142,966.5 сая төгрөгөөр баталсан бол АИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 08-ны 11/04 дүгээр тогтоолоор 21,140.8 сая төгрөгөөр өсгөж, 164,107.3 сая төгрөгөөр баталсан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит XIII хуралдааны 13/09 дүгээр тогтоолоор 2023 оны төсвийн нийт орлогын эх үүсвэрийг 256,878.7 сая төгрөгөөр баталсныг 2023 оны 07 дугаар сарын 08-ны 11/04 дүгээр тогтоолоор 293,493.7 сая төгрөг буюу 36,615.0 сая төгрөгөөр өсгөж тодотгосон байна.

*Хүснэгт №2 Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөлт /сая төгрөг/*

№	Орлогын эх үүсвэр	Анх баталсан /2022.12.02 №13/09/	Тодотгосон /2023.07.08 №11/04/	Тодотгосон /2023.10.03 №12/02/	Зөрүү
1	Татварын орлого	107,000.0	127,000.0	127,000.0	20,000.0
2	Татварын бус орлого	18,444.0	18,444.0	18,444.0	-
3	Тусламжийн орлого	111,542.2	122,378.5	122,378.5	10,836.3
4	Урьд оны шилжих үлдэгдэл	19,892.5	25,671.1	25,671.1	5,778.7
	<b>Дүн</b>	<b>256,878.7</b>	<b>293,493.6</b>	<b>293,493.6</b>	<b>36,615.0</b>

Орон нутгийн төсвийн татварын бус орлогод өөрчлөлт ороогүй бөгөөд татварын орлогыг 20,000.0 сая, тусламжийн орлогыг 10,836.3 сая, урьд оны шилжих үлдэгдлийг 5,778.7 сая нийт 36,615.0 сая төгрөгөөр өсгөж тодотгосон нь Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулж тодотгосонтой холбоотой байна.

Мөн Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоол хэрэгжсэнтэй холбоотой цалингийн санг нэмж тодотгосон байна.

Эрдэнэт сангийн орлогыг 7,683.5 сая төгрөгөөр анх баталж тодотголоор 4,795.5 сая төгрөг болгон 2,888.0 сая төгрөгөөр бууруулан баталсан.

Орхон аймаг, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын 2023 оны хамтын ажиллагааны хүрээнд хийгдэх арга хэмжээний санхүүжилтийг 3,000.0 сая төгрөгөөр оны эхэнд Эрдэнэт санд төлөвлөсөн байсныг 2023 оны 07 дугаар сарын 08-ны төсвийн тодотголоор орон нутгийн хөгжлийн сангийн орлогын эх үүсвэр талд шилжүүлэн тодотгон баталжээ.

*Хүснэгт №3 Эрдэнэт сангийн орлогын төлөвлөлт*

*/сая төгрөг/*

№	Орлогын төрөл	Анх баталсан 2022.12.02 №13/10	Тодотгосон 2023.07.08 №11/05	Зөрүү
1	Реклам, сурталчилгааны самбараас орох орлого	16.1	16.1	0.0
2	Гэр бүл хүүхэд залуучуудын газрын үйл ажиллагааны орлого	35.0	35.0	0.0
3	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагааны орлого	90.3	90.3	0.0
4	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай 2020 оны хамтын ажиллагааны хүрээнд орох орлого	2,921.3	2,921.3	0.0
5	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тай 2023 оны хамтын ажиллагааны хүрээнд орох орлого	3,000.0	0	(3,000.0)
6	Урьд оны шилжих үлдэгдэл	1,620.8	1,732.8	112.0
	<b>Дүн</b>	<b>7,683.5</b>	<b>4,795.5</b>	<b>2,888.0</b>

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын үйл ажиллагааны орлогод 90.3 сая төгрөгийг төлөвлөж, гүйцэтгэлээр 90.3 сая төгрөгийг бүрэн төвлөрүүлж, байгууллагад хөрөнгө бэлтгэх зардлаар төлөвлөгдсөн байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын төсөвт төвлөрүүлж буй орлого нь газар эзэмших эрхийн төлбөр бөгөөд Газрын тухай хуулийн 33.1.2-д “энэ хуулийн 33.1.1-д зааснаас бусад зориулалтаар болон энэ хуулийн 29.1, 29.2, 29.3-т заасан хэмжээнээс илүү газар эзэмших хүсэлт гаргасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад газар эзэмшүүлэх асуудлыг аймаг, сум, нийслэлийн Засаг дарга дуудлага худалдаа, төсөл шалгаруулах зарчмаар шийдвэрлэнэ. Төсөл шалгаруулах, дуудлага худалдаа явуулах журмыг Засгийн газар тогтооно”, Газрын төлбөрийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Газрын төлбөрийн орлогыг аймаг, сум, нийслэл, дүүргийн төсөвт оруулна” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын Эрдэнэт санд төвлөрүүлж буй газрын эрхийн үнийг орон нутгийн төсөвт төлөвлөн, бүрэн төвлөрүүлэх шаардлагатай тул зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэв.

1.2 Төсвийн орлого нийт дүнгээрээ 2.6 хувиар давж биелсэн ч татварын бус орлогын төлөвлөгөө 29 хувиар тасарсан байна.

Аймгийн татварын орлогын гүйцэтгэл 108.1 хувь буюу 19,397.2 сая төгрөгөөр давж биелсэн байна.

*Хүснэгт №4 Орон нутгийн татварын орлогын биелэлт*

*/сая төгрөг/*

Орлогын нэр төрөл	2022 оны гүйцэтгэл	2023 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин хөлс түүнтэй адилтгах орлого	50,601.8	58,408.6	59,481.8	1,073.2	102
Үйл ажиллагааны орлого	428.1	463.0	544.5	81.5	118

Хөрөнгийн орлого /хадгаламжийн хүү/	2,487.1	3,242.9	3,005.4	(237.5)	93
Хөрөнгө борлуулсны орлого	2,449.4	2,358.5	3,743.4	1,385.4	159
Шууд бус орлого	933.7	1,500.0	1,264.4	(235.6)	84
ХХОАТ-ын буцаалт	-3,802.0	-4,484.3	-4,484.3	0.0	100
Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	71,873.7	125,000.0	138,850.6	13,850.6	111
Үл хөдлөх хөрөнгийн татвар	22,455.3	21,400.0	20,016.5	(1,383.5)	94
Бууны татвар	57.2	40.8	48.0	7.2	118
АТБӨЯХАТатвар	1,182.8	1,100.0	1,273.7	173.7	116
Малд ногдуулах албан татвар	33.7	38.7	41.7	3.0	108
Улсын тэмдэгтийн хураамж	501.1	601.5	654.5	53.0	109
Түгээмэл тархацтай ашигт малтмалын орлогын албан татвар	67.5	64.5	69.4	4.9	108
Хог хаягдлын хураамж	1,612.3	1,450.5	1,728.4	277.9	119
Бусад татвар	496.5	0.2	686.1	685.9	311.8
Газрын төлбөр	23,107.5	26,515.0	29,419.4	2,904.4	111
Газрын дуудлага худалдаа	108.5		586.5	586.5	
Ойн нөөц ашигласны төлбөр	20.1	2.5	2.5	0.0	100
Ус рашааны нөөц ашигласны төлбөр	328.7	355.1	521.8	166.8	147
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр		1.2	1.3	0.1	108
<b>Дүн</b>	<b>174,943.0</b>	<b>238,058.2</b>	<b>257,455.4</b>	<b>19,397.2</b>	<b>108.1</b>

Орон нутгийн төсөвт төвлөрөх 2023 оны татварын орлогыг 238,058.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 257,455.4 сая төгрөг төвлөрч 19,397.2 сая төгрөгөөр давж биелсэн байна. Татварын орлогыг биелэлтээр авч үзвэл дараах шалтгаантай байна.

- **Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын албан татварын орлогыг** 58,408.6 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 59,481.8 сая төгрөг төвлөрч 1,073.2 сая төгрөг буюу 2 хувиар давсан нь “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын ажиллагсдын цалин болон Төрийн албан хаагчдын албан тушаалын цалингийн хэмжээг Засгийн газраас шинэчлэн тогтоосонтой холбоотой байна.
- **Хөрөнгө борлуулсны орлого** 2,358.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 3,743.4 сая төгрөг төвлөрч, 1,385.3 сая төгрөг буюу 59 хувиар давж биелсэн буюу өмнөх оны гүйцэтгэлээс 1,294.0 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- **ААН-ийн орлогын албан татварыг** 125,000.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 138,850.6 сая төгрөг төвлөрч, 13,850.6 сая төгрөг буюу 11 хувиар давж биелсэн.
- **Хөрөнгийн орлогын татварыг** 3,242.8 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 3,005.3 сая төгрөг төвлөрч, 237.5 сая төгрөг буюу 0.7 хувиар дутуу төвлөрсөн нь хадгаламж эзэмшигчийн тоо, хадгаламжийн мөнгөн дүн буурсантай холбоотой байна.
- **Үл хөдлөх хөрөнгийн татварыг** 21,400.0 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 20,016.4 сая төгрөг төвлөрч, 1,383.6 сая төгрөг буюу 0.6 хувиар дутуу төвлөрсөн нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын хөрөнгийн дахин үнэлгээ хийж хөрөнгийн үнэлгээ буурсантай холбоотой байна.

- **Шууд бус орлогыг** 1,500.0 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 1,264.4 сая төгрөг төвлөрч, 235.6 сая төгрөг буюу 16 хувиар дутуу төвлөрсөн өмнөх оны гүйцэтгэлээс өндрөөр төлөвлөсөн байна.

1.3 Аймгийн татварын бус орлогын төлөвлөгөө 71 хувь буюу 12,140.9 сая төгрөгөөр тасарсан байна.

Татварын бус орлогыг 41,806.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 29,665.5 сая төгрөг төвлөрч 12,140.9 сая төгрөгөөр орлого тасарсан байна.

*Хүснэгт №5 Орон нутгийн татварын бус орлогын биелэлт /сая төгрөг/*

Орлогын нэр төрөл	2022 оны гүйцэтгэл	2023 он			
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Торгуулийн орлого	1,689.9	1,490.0	2,090.5	600.5	124
Үндсэн үйл ажиллагаанаас санхүүжих орлого	7,399.3	3,572.0	1,512.6	(2,059.4)	42
Туслах үйл ажиллагаанаас санхүүжих орлого	16.4				0
Түрээсийн орлого		430.9	486.0	55.1	113
Бусад орлого	280.1		1,798.6	1,798.6	
Хөрөнгийн орлого /ТБОНӨБХБ/		16,543.2	4,432.8	(12,110.3)	27
Хандив тусламж	19,205.7	2,800.0	2,600.0	(200.0)	93
Орон нутгийн хөгжлийн сангаас шилжүүлсэн орлого	9,836.2	16,970.4	16,782.3	(188.2)	99
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	30.0				0
<b>Дүн</b>	<b>38,457.6</b>	<b>41,806.5</b>	<b>29,702.8</b>	<b>(12,103.7)</b>	<b>71</b>

- Үндсэн үйл ажиллагаанаас санхүүжих орлогыг 3,571.9 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 1,512.6 сая төгрөг төвлөрч, 2,059.4 сая төгрөгөөр дутуу буюу 42 хувийн биелэлттэй байна. Энэ нь Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-аас цэцэрлэгт хүрээлэнгийн дутуу ажлын санхүүжилт 2,921.3 сая төгрөгийг эрдэнэт сангийн өөрийн орлого дээр төлөвлөсөн ч ажил нь хэрэгжээгүй тул санхүүжилт орж ирээгүйтэй холбоотой байна.
- Хөрөнгийн орлогыг 16,543.1 сая төгрөгөөр төлөвлөн, гүйцэтгэлээр 4,432.8 сая төгрөг төвлөрч 12,110.3 сая төгрөг дутуу буюу 27 хувийн биелэлттэй байгаа нь 258 айлын орон сууц, 75 машины гарааш ашиглалтад орохоос 104 айлын орон сууц ашиглалтад орж 60 орон сууц худалдан борлуулсны орлого 4,432.8 сая төгрөг төвлөрсөн байна. Үлдсэн 40 айлын орон сууцыг иргэдэд түрээсийн хэлбэрээр эзэмшүүлсэн гэх боловч одоогоор төсөвт орсон орлого байхгүй, гэрээ байгуулж баталгаажуулаагүй байна.
- Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 16,970.4 сая төгрөг төвлөрөхөөс 188.1 сая төгрөгийн санхүүжилт дутуу орсон. Энэ нь 2023 онд улсын хэмжээнд төсөвт төвлөрдөг газрын тосны орлого тасарсан, орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж байгууллагууд орлогоо бүрэн төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.

Татварын бус орлогын төлөвлөгөө 29 хувиар тасарсан нь татварын бус орлогыг бодитой төлөвлөж, батлах үйл явцад хяналт хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.

**БҮЛЭГ 2: ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ СУЛ ДУТМАГААС ХЭТ ӨНДӨР ХЭМНЭЛТ ҮҮСЭХ ЭРСДЭЛ НЭМЭГДСЭН БАЙНА.**

2.1 Төсвийн зарлагыг бодитой төлөвлөөгүйгээс хэт өндөр хэмнэлт үүсэх, төсвийн зарцуулалтыг байгууллага бүртэй тооцоо нийлж акт үйлдээгүй нь хяналт дутмаг байгааг харуулж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 12/09 дүгээр тогтоолоор орон нутгийн 2023 оны төсвийн зардлыг 256,878.7 сая төгрөгөөр баталсан ба 2023 оны 07 дугаар сарын 08-ны 11/04 дүгээр тогтоолоор 36,614.9 сая төгрөгөөр нэмж тодотгосон байна.

*Хүснэгт №6 Орон нутгийн төсвийн зардал, тодотгоол /Аймаг/ /сая төгрөг/*

№	Зарцуулах эрх, эх үүсвэр	Анх баталсан 2022.12.02 №13/09	Тодотгосон 2023.07.08 №11/04	Тодотгосон 2023.10.03 №12/02	Зөрүү
1	Орон нутгийн төсвийн байгууллага	22,128.60	26,351.35	26,351.35	4,222.75
2	Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	5,437.38	6,100.04	6,100.04	662.66
3	Хөрөнгө оруулалт	73,625.92	82,505.47	82,505.47	8,879.55
4	Орон нутгийн хөгжлийн сан /сумдын/	7,417.57	9,126.73	9,126.73	1,709.16
5	Төрийн болон орон нутгийн өмчийн барилгын үйлчилгээний ашиглалтын зардал	5,302.77	5,302.77	5,302.77	0.00
6	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	142,966.51	164,107.31	164,107.31	21,140.8
	<b>Дүн</b>	<b>113,912.24</b>	<b>129,386.36</b>	<b>129,386.36</b>	<b>36,614.93</b>

*Хүснэгт №7 Орон нутгийн төсвийн зардал, тодотгоол /Баян-өндөр сум/ /сая төгрөг/*

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	Баян-Өндөр сумын ИТХ-ын 2022.12.19 №05	Баян-Өндөр сумын ИТХ-ын 2023.07.19 №14/02	Зөрүү /өсөлт + бууралт-/
1	Орон нутгийн төсвийн байгууллага	4,824.5	5,531.7	707.2
2	Хөрөнгө оруулалт	1,108.1	1,138.1	30.0
3	Төсөл, хөтөлбөр	604.3	634.3	30.0
4	Сумын орон нутгийн хөгжлийн сан	3,668.8	4,413.9	745.0
5	Төсөвт төвлөрүүлэх орлого	97,983.1	102,601.0	4,618.0
	<b>Нийт дүн</b>	<b>108,188.9</b>	<b>114,319.1</b>	<b>6,130.2</b>

*Хүснэгт №8 Орон нутгийн төсвийн зардал, тодотгоол /Жаргалант сум/ /сая төгрөг/*

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	Жаргалант сумын ИТХ-ын 2022.12.19 №10	Жаргалант сумын ИТХ-ын 2023.07.19 №01	Зөрүү /өсөлт + бууралт-/
1	Орон нутгийн төсвийн байгууллага	2,601.0	2,986.4	385.4
2	Хөрөнгө оруулалт	3,400.0	3,350.0	(50.0)
3	Төсөл, хөтөлбөр	785.2	1,190.9	405.7
4	Сумын орон нутгийн хөгжлийн сан	4,093.5	4,969.1	875.6
5	Хоршоог хөгжүүлэх сан	226.8	226.8	-
6	Төсөвт төвлөрүүлэх орлого	1,170.2	1,164.2	(6.0)
	<b>Нийт дүн</b>	<b>12,276.7</b>	<b>13,887.4</b>	<b>1,610.7</b>

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 08-ны 11/04 дүгээр тогтоолоор төсөв тодотгохдоо Орон нутгийн төсвийн байгууллага арга хэмжээнд 4,222.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 26,351.4 сая төгрөг болгосон нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Аймгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурал 2,707.4 сая төгрөгийн төсөв баталсныг тодотголоор 2,926.7 сая төгрөг болгон 219.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Аймгийн Засаг даргын тамгын газар 3,375.9 сая төгрөгөөс 3,964.4 сая төгрөг буюу 606.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Хот тохижуулах газар 6,699.3 сая төгрөгөөс 8,593.5 сая төгрөг буюу 1,871.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Байгаль орчин, аялал жуулчлалын газар 361.4 сая төгрөгөөс 514.1 сая төгрөг буюу 152.7 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Нийтлэг үйлчилгээний алба 914.7 сая төгрөгөөс 1,193.5 сая төгрөг буюу 278.8 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Эрдэнэт хотын хог хаягдлын менежментийг сайжруулах төслийн гаалийн төлбөр, хураамжийн зардал 3,841.3 сая төгрөгөөс 2,953.4 сая төгрөг буюу 887.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн.
- Төрийн захиргааны байгууллагын албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл 1,266.9 сая төгрөгийг олгохоор тус тус тодотгожээ.

Аймгийн төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг 307,911.7 сая төгрөгөөр төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 273,372.8 сая төгрөг буюу 88.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн нэгтгэсэн төсвийн нийт зарлагад урсгал зардал 213,213.3 сая төгрөг буюу 78.0 хувь, хөрөнгийн зардал 60,159.6 сая төгрөг буюу 22.0 хувийг эзэлж байна.

**Хүснэгт №9 Орон нутгийн төсвийн зардлын гүйцэтгэл /сая төгрөг/**

№	Үзүүлэлт	2022	2023 он		Биелэлт	
		Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл	10,699.7	17,481.6	16,986.0	495.6	97.2
2	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	3,429.2	5,582.1	4,275.7	1,306.3	76.6
3	Хангамж, бараа материалын зардал	1,940.6	2,715.0	2,447.3	267.6	90.1
4	Норматив зардал	119.0	167.6	164.7	2.9	98.3
5	Эд хогшил, урсгал засварын зардал	1,287.8	2,396.0	2,265.0	131.0	94.5
6	Томилолт, зочны зардал	62.6	233.6	190.9	42.8	81.7
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	18,454.9	23,234.1	18,671.9	4,562.2	80.4
8	Бараа үйлчилгээний бусад зардал	1,640.0	1,550.9	1,221.3	329.6	78.7
9	Татаас, урсгал шилжүүлэг	93,698.7	167,583.6	166,990.5	593.1	99.6
10	Хөрөнгийн зардал	52,871.9	86,340.6	59,646.2	26,694.4	69.1
11	Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	383.1	626.8	513.4	113.4	81.9
	<b>Нийт дүн</b>	<b>184,587.7</b>	<b>307,911.8</b>	<b>273,372.8</b>	<b>34,538.9</b>	88.8

Орон нутгийн төсвийн зардлын гүйцэтгэлийг дээрх хүснэгтээс үзэхэд:

- Татаас, урсгал шилжүүлэг зардал өмнөх онтой харьцуулахад 73.8 сая төгрөгөөр өссөн нь Улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийн дүн өмнөх оноос нэмэгдсэнтэй холбоотой байна.

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардлын гүйцэтгэл 76.6 хувьтай байгаа нь тайлант онд Баян-Өндөр цэцэрлэг, Номын өргөө цогцолбор ашиглалтад орохоор төлөвлөж байр ашиглалтын зардлыг төсөвт суулгасан боловч төлөвлөсөн хугацаандаа ашиглалтад ороогүй, Найрамдал, Чандмань 2 баг шинээр байгуулагдаж, түрээсийн зардлыг төсөвт тусган баталсан боловч 2023 ондоо түрээсийн зардал гараагүйтэй холбоотой байна.
- Бараа үйлчилгээний бусад зардлын гүйцэтгэл 78.75 хувьтай байгаа нь Засаг даргын нөөц сангийн журмын 2.1.1, 2.1.2-т заасан арга хэмжээнд зарцуулах 30%-ийн нөөцийг дансанд бэлэн байлгах заалтын дагуу үлдэгдлийг тооцон зарцуулаагүй төвлөрүүлсэн, ахмадын байгууллагад олгох санхүүжилтийг өөр зардал ангиллаас зарцуулсан, зарим төлөвлөн хийгдсэн арга хэмжээнээс үүссэн хэмнэлт байна.
- Томилолт, зочны зардал 2022 оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад 3 дахин өссөн нь дотоод болон гадаад томилолт нэмэгдсэнтэй холбоотой байна.
- Хөрөнгийн зардлын төсөв 2022 оны төсвөөс 1.3 дахин нэмэгдүүлэн баталсан боловч гүйцэтгэлээр 69.1 хувьтай байгаа нь худалдан авах ажиллагаа зарлах болон гэрээ байгуулах шатанд удаашрах, ажил эхлүүлэх зөвшөөрөл авах явцад материал бүрдүүлэх, газар доогуур орсон шугам, агаарын шугам дайрсан газруудад техникийн нөхцөлүүд бүрдүүлэх гэх мэт шалтгаанаас хамаарч ажил оройтон эхлэх цаашид гэрээт ажил үргэлжлэн хийхэд дулааны улирал дуусаж гадна температур буурах барилгын норм дүрэмд зааснаар ажил үргэлжлэн хийгдэх боломжгүй болдог зэрэг хүчин зүйлийг үнэлж дүгнэлгүй төсөв боловсруулж байгаатай холбоотой байна.
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал 80.4 хувийн гүйцэтгэлтэй буюу 4,562.2 сая төгрөгийн хэмнэлт үүссэн нь Орхон аймаг Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-тэй байгуулсан хамтын ажиллагааны хүрээнд 3,400.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажил хийгдээгүйгээс санхүүжилт олгоогүйтэй холбоотой байна.

Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам” -ын 5, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11/04 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтад заасны дагуу Улсын төсвийн төрийн захиргааны 16 байгууллагад 1,266.9 сая төгрөгийг орон нутагт ажилласны нэмэгдэл олгох төсвийг баталсан байна.

*Хүснэгт №10 Улсын төсвийн захиргааны байгууллагын албан хаагчдын орон нутагт ажилласны нэмэгдэл /сая төгрөг/*

Д/д	Байгууллагын нэр	Баталсан төсөв	Гүйцэтгэлээр олгосон дүн	Хэтрэлт хэмнэлт
1	Статистикийн хэлтэс	22.5	18.9	3.5
2	Стандарт хэмжил зүйн хэлтэс	56.2	47.7	8.5
3	Татварын хэлтэс	163.5	111.9	51.6
4	Улсын бүртгэлийн хэлтэс	83.3	68.3	15.0
5	Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар	151.6	121.0	30.6
6	Хүнс, хөдөө аж ахуйн газар	72.7	58.5	14.2
7	Мал эмнэлгийн газар	60.9	45.5	15.4
8	Эрүүл мэндийн газар	121.8	78.5	43.3
9	Нийгмийн даатгалын хэлтэс	132.3	93.3	39.0
10	Сэлэнгэ голын сав газрын захиргаа	28.1	24.7	3.3
11	Соёл, урлагийн газар	38.4	38.4	0.0
12	Боловсрол, шинжлэх ухааны газар	87.1	72.3	14.8

13	Орхон аймгийн Биеийн тамир спортын газар	46.5	39.1	7.4
14	Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар	83.0	54.8	28.2
15	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар	103.6	88.3	15.4
16	Эрүүл мэндийн даатгалын хэлтэс	15.4	12.5	3.0
17	Ус, цаг уур, орчны шинжилгээний төв		50.6	-50.6
<b>Нийт дүн</b>		<b>1,266.9</b>	<b>1,024.2</b>	<b>242.7</b>

Улсын төсвийн төрийн захиргааны 16 байгууллагын 279 төрийн захиргааны албан хаагчийн үндсэн цалингийн 40 хувиар 954.7 сая төгрөг, 129 төрийн үйлчилгээний албан хаагчийн үндсэн цалингийн 40 хувиар 312.2 сая төгрөг нийт 408 албан хаагчийн орон нутгийн нэмэгдэлд 1,266.9 сая төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр 17 байгууллагын 429 албан хаагчид 1,089.1 сая төгрөгийн орон нутгийн нэмэгдлийг цалингийн тооцооллыг үндэслэн Засаг даргын төсөл хөтөлбөрийн зардлаас санхүүжилтийг олгосон байна.

Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн албан хаагчид олгох орон нутагт ажилласны нэмэгдлийн төсөвт батлаагүй, аймгийн Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 31 өдрийн А/654 дүгээр захирамжаар төсөвт зохицуулалт хийж 50.6 сая төгрөгийн нэмэгдлийг олгосон байна.

Төрийн захиргааны байгууллагад олгосон орон нутгийн нэмэгдлийн хэмнэлтийг Татварын хэлтэс 19.6 сая төгрөг, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар 30.6 сая төгрөг нийт 50.2 сая төгрөгийг буцаан Төсөл хөтөлбөрийн дансанд төвлөрүүлсэн бол бусад төрийн байгууллагуудтай оны эцэст тооцоо нийлээгүйгээс 192.1 сая төгрөгийг улсын төсвийн дансанд төвлөрүүлсэн байна.

Иймд Төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн оны эцэст байгууллага бүртээ тооцоо нийлж, үүссэн хэмнэлтийг дансанд буцаан төвлөрүүлж байх шаардлагатай тул зөвлөмж хүргүүлэв.

2.2 Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "Нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу нэмэлт санхүүжилтийн дансны орлогыг нэр төрлөөр бүртгэж, зардлын зүйл тус бүрээр эрх нээн зарцуулж, төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан байна.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудын нэмэлт санхүүжилтийн дансанд 4,725.4 сая төгрөгийн орлого төвлөрч, 2,558.65 сая төгрөгийг зарцуулан, түрээсийн орон сууцны төлбөр 2,001.6 сая төгрөгийг Хөгжлийн банканд, орон нутгийн төсөвт 165.1 сая төгрөгийг төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт № 11 Нэмэлт санхүүжилтийн орлогын судалгаа /сая төгрөг/*

№	Эх үүсвэрийн төрөл	2022 он	2023 он	Өсөлт + /бууралт-
1	Засгийн газрын нөөц хөрөнгө, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгийн эх үүсвэр	3,628.5	2,092.1	(1,536.4)
2	Дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагчаас хуваарилсан эх үүсвэр	2,127.2	382.0	(1,745.2)



3	Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,764.6	2,251.3	486.7
	<b>Нийт дүн</b>	<b>7,520.3</b>	<b>4,725.4</b>	<b>(2,794.9)</b>

Нийт зарцуулалтын 2,558.7 сая төгрөгийн 99.9 хувь буюу 2,556.3 сая төгрөгийг урсгал зардалд, 0.01 хувь буюу 2.4 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

*Хүснэгт № 12 Нэмэлт санхүүжилтийн зардлын гүйцэтгэл /сая төгрөг/*

№	Зардлын төрөл	2022 он	2023 он	Өсөлт + /бууралт-
1	Цалин хөлс, НДШ-ийн зардал	392.5	254.4	(138.1)
2	Байр ашиглалтын зардал	154.3	0.9	(153.4)
3	Хангамж, бараа материалын зардал	384.7	412.1	27.4
4	Норматив зардал	72.9	32.1	(40.8)
5	Урсгал засвар, эд хогшлын зардал	248.2	472.7	224.5
6	Томилолтын зардал	11.3	1.6	(9.7)
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ, төлбөр хураамж	3,718.7	1,010.7	(2,708.0)
8	Бараа үйлчилгээний бусад зардал	2,074.1	2,189.5	(115.4)
9	Тэтгэмж урамшууллын зардал	395.8	349.0	(46.8)
10	Хөрөнгийн зардал	78.0	2.4	(75.6)
	<b>Нийт дүн</b>	<b>7,530.5</b>	<b>4,725.4</b>	<b>(2,805.1)</b>

Нэмэлт санхүүжилтийн дансны тайлангийн нийт зардлыг өмнөх онтой харьцуулахад 2,805.1 сая төгрөгөөр буюу 37.3 хувиар буурсан байгаа нь боловсролын байгууллагын үйл ажиллагааны зардал хасагдсан нь шалтгаалжээ.

**БҮЛЭГ 3. ЗАСАГ ДАРГЫН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ 91.7 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА.**

3.1 Аймгийн 2023 оны худалдан авах ажиллагаанаас 6,325.7 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 13/09 дүгээр тогтоолоор орон нутгийн хөрөнгө оруулалтыг 60,576.4 сая төгрөгөөр баталсныг 2023 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 11/04 дугаар тогтоол, 2023 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 12/02 дугаар тогтоолоор өөрчлөлт оруулж 64,961.2 сая төгрөг болгон 4,384.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

*Хүснэгт №13 Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөлт /аймаг/*

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	Анх баталсан 2022.12.02 №13/09	Тодотгосон 2023.07.08 №11/04	Тодотгосон 2023.10.03 №12/02	Зөрүү
1	Шилжих хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	27,307.8	27,551.5	27,551.5	243.7
2	Шинэ хөрөнгө оруулалт	23,586.7	26,037.7	26,052.2	2,465.6
3	Төсөл, хөтөлбөр	9,681.9	11,357.5	11,357.5	1,675.6
	<b>Дүн</b>	<b>60,576.4</b>	<b>64,946.8</b>	<b>64,961.2</b>	<b>4,384.9</b>

**Хүснэгт №14 Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөлт /Баян-өндөр сум/**  
/сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	Баян-Өндөр сумын ИТХ-ын 2022.12.19 №05	Баян-Өндөр сумын ИТХ-ын 2023.07.19 №14/02	Зөрүү /өсөлт + бууралт-/
1	Шинэ хөрөнгө оруулалт	1,108.1	1,138.1	30.0
2	Төсөл, хөтөлбөр	604.3	634.3	30.0
	<b>Дүн</b>	<b>1,712.4</b>	<b>1,772.4</b>	<b>60.0</b>

**Хүснэгт №15 Орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлын төлөвлөлт /Жаргалант сум/**  
/сая төгрөг/

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	Жаргалант сумын ИТХ-ын 2022.12.19 №10	Жаргалант сумын ИТХ-ын 2023.07.19 №01	Зөрүү /өсөлт + бууралт-/
1	Шинэ хөрөнгө оруулалт	3,400.0	3,350.0	(50.0)
2	Төсөл, хөтөлбөр	785.2	1,190.9	405.7
	<b>Дүн</b>	<b>4,185.2</b>	<b>4,570.8</b>	<b>385.7</b>

Тайлант онд хэрэгжүүлэхээр 57,292.2 сая төгрөгийн өртөгтэй 413 төсөл арга хэмжээг “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн хүрээнд мөрдөгдөж буй 9 аргаар хэрэгжүүлэхээр 506 удаагийн сонгон шалгаруулалтыг зарлаж 398 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр 50,897.4 сая төгрөгийн гэрээ байгуулж, 6,394.7 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

**Хүснэгт №16 Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, гүйцэтгэл** /сая төгрөгөөр/

Д/д	Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний эх үүсвэр	TAX тоо	Төсөвт өртөг	Тайлант онд шилжих дүн	Гэрээний дүн	Хэмнэлт + хэтрэлт-
1	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт	117	23,769.4	22,708.0	19,846.1	3,923.3
2	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	23	5,892.0	5,790.2	5,142.5	749.5
3	Байгаль хамгаалах сан	14	3,578.9	3,578.9	3,329.2	249.7
4	Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	1	335.0	335.0	333.7	1.3
5	Улсын төсвийн хөрөнгө оруулалт	2	3,801.1	3,801.1	3,548.0	253.1
6	Шилдэг аймгийн урамшуулал	1	65.6	65.6	62.2	3.4
7	Аймгийн авто замын сан	1	30.0	30.0	29.7	0.4
8	Эрдэнэт сан	4	90.4	90.4	89.0	1.3
9	Зураг төсөв	11	588.7	515.7	320.8	268.0
10	Баян-Өндөр сумын ОНХС	82	3,653.9	3,653.9	3,501.7	152.2
11	Жаргалант сумын ОНХС	55	10,983.3	8,344.8	10,635.2	348.1
12	Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж	2	120.3	120.3	111.6	8.7
13	Хот тохижуулах	11	1,639.7	1,639.7	1,571.3	68.4
14	Эрдэнэт ус ДТС ОНӨХК	89	2,744.0	2,744.0	2,376.6	367.3
	<b>Дүн</b>	<b>413</b>	<b>57,292.2</b>	<b>53,417.5</b>	<b>50,897.4</b>	<b>6,394.7</b>

Төсөл арга хэмжээний 15 сонгон шалгаруулалтад оролцогч материал ирүүлээгүй, ирүүлсэн баримтууд шаардлага хангаагүйгээс шалтгаалан худалдан авах ажиллагаа хэрэгжээгүй байна.

*Хүснэгт №17 Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам, арга хэмжээ /сая төгрөг/*

Д/д	Худалдан авах ажиллагаанд мөрдсөн журам, арга	TAX тоо	Төсөвт өртөг	Тайлант онд шилжих дүн	Гэрээний дүн
1	Нээлттэй тендер шалгаруулалтын арга	102	45,333.3	41,547.0	39,764.0
2	Бага үнийн арга	7	302.1	302.1	207.7
3	ЗСБҮА	3	163.0	163.0	157.1
4	ОНОХА	4	62.5	62.5	62.3
5	Хосолмол үнэлгээний арга	2	246.6	173.7	91.1
6	Гэрээ шууд байгуулах арга	1	45.0	45.0	45.0
7	Шууд худалдан авалтын арга	171	2,425.2	2,425.2	2,356.8
8	Харьцуулалтын арга	121	6,526.4	6,511.0	6,025.6
9	Ерөнхий гэрээний журам	2	2,188.0	2,188.0	2,187.9
	Нийт дүн	413	<b>57,292.2</b>	<b>53,417.5</b>	<b>50,897.4</b>

Худалдан авах ажиллагаанд мөрдсөн төсөл арга хэмжээний 41.4 хувийг шууд худалдан авалтын аргаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс 33,087.1 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэгчид олгож, техник хяналтын 821.2 сая, барьцаа хөрөнгийн 1,922.0 сая төгрөгийг орон нутгийн барьцаа хөрөнгө, техникийн хяналтын дансанд төвлөрүүлж, орон нутгийн ерөнхий орлогын дансанд 234.1 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нийт батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнээс 18,007.4 сая төгрөгийн төсөл арга хэмжээний гүйцэтгэл гараагүй, он дамжин хэрэгжиж буй шалтгаан нь худалдан авах ажиллагаа зарлах болон гэрээ байгуулах шатанд удаашрах, төсөл арга хэмжээний ажил эхлүүлэх зөвшөөрөл авах явцад материал бүрдүүлэх, газар доогуур орсон шугам, агаарын шугам дайрсан газруудад техникийн нөхцөлүүд бүрдүүлэх гэх мэт хүчин зүйлээс хамааралтай ажил оройтон эхлэх, цаашид гэрээт ажил үргэлжлэн хийхэд дулааны улирал дуусаж гадна температур буурах барилгын норм дүрэмд зааснаар ажил үргэлжлэн хийгдэх боломжгүй болдог байна.

Иймд батлагдсан төсвийн зарцуулалтыг оновчтой, үр ашигтай болгохын тулд хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг бодитой төлөвлөж, худалдан авах ажиллагааг оновчтой зохион байгуулах шаардлагатай тул зөвлөмж хүргүүлэв.

3.2 Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, арга, хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл өмнөх оноос 2.21 хувиар өссөн ч хөрөнгө оруулалтын гүйцэтгэл өмнөх оноос 15 хувиар буурсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрт хамрагдах 25 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталжээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанар болон тоон хэмжээний үзүүлэлт, зарцуулах төсвийг баталж, үр дүнг зарцуулсан зардлын гүйцэтгэлтэй харьцуулж ирүүлсэн хэдий ч дүн шинжилгээ хийгээгүй байна.

*Хүснэгт №18 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөг/*

№	Хөтөлбөр	Жилийн төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага	3,414.1	3,236.9	177.2	94.8
2	70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага	95,046.6	89,186.7	5,859.9	97.1
3	70426 Төрийн өмчийн эрхийг хэрэгжүүлэх	566.3	543.4	23.0	95.9
4	70427 Төрийн нийтлэг бусад үйлчилгээ	1,193.5	1,154.1	39.4	96.7
5	70429 Санхүүгийн хяналт, дотоод аудит, эрсдэлийн удирдлага	335.1	332.5	2.6	99.2
6	70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт	80,547.5	56,426.7	24,120.8	70.1
8	70709 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх	467.0	428.0	39.0	91.6
9	70801 Мал аж ахуйг хөгжүүлэх	36.3	36.3	0.0	100.0
10	71101 Авто зам	2,138.4	2,135.7	2.7	99.9
11	71302 Мэдээллийн нэгдсэн тогтол дэд бүтэц	237.6	235.2	2.3	99.0
12	71403 Ойжуулалт	337.7	318.3	19.4	94.3
13	71411 Хүрээлэн буй орчны бодлого, удирдлага	514.1	502.0	12.1	97.6
14	71413 Байгал орчин хамгаалан нөхөн сэргээх	4,108.3	1,508.8	2,599.5	36.7
15	71502 Хот байгуулалт, тохижилт	9,703.8	9,297.6	406.2	95.8
16	71509 БХБНААХуйн бодлого удирдлага	462.6	459.5	3.2	99.3
17	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	68.9	64.1	4.8	93.0
18	71701 Биеийн тамир спорт	45.7	45.7	0.1	99.8
19	71702 Соёл урлаг	331.5	259.5	72.1	78.3
20	71801 Сургуулийн өмнөх боловсрол	2,354.2	1,724.4	629.8	73.2
21	71802 Ерөнхий боловсрол	2,181.1	1,836.5	344.5	84.2
22	71804 Мэргэжлийн боловсрол	391.8	352.2	39.6	89.9
23	71806 Насан туршийн болон албан бус боловсрол	55.8	41.0	14.8	73.5
24	71902 Нийгмийн халамж	138.0	130.7	7.3	94.7
25	72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	635.0	516.2	118.8	81.3
	<b>Дүн</b>	<b>307,911.8</b>	<b>273,372.8</b>	<b>34,538.9</b>	<b>91.7</b>

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 34,538.9 сая төгрөг хэмнэж, 273,372.8 сая төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 91.7 хувьтай байгаа нь

- Байгал орчин хамгаалан нөхөн сэргээх зардал 36.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Хот тохижуулах газарт автомашин худалдан авах арга хэмжээ тайлант онд хэрэгжээгүйтэй холбоотой.
- Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 70.1 хувьтай байгаа нь хөрөнгө оруулалтыг тооцоо судалгаа багатай төлөвлөж байгаатай холбоотой бөгөөд өмнөх онд 85% гүйцэтгэлтэй байсан бол энэ онд 15 хувиар буурсан байна.
- Соёл урлаг хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 78.3 хувьтай байгаа нь Номын өргөө барилгын ашиглалтын зардлыг төлөвлөсөн боловч хугацаанаасаа хойшилж тайлант онд ашиглалтад ороогүйтэй холбоотой хэмнэлт үүссэн байна.
- Сургуулийн өмнөх боловсрол 73.2 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Баян-Өндөр цэцэрлэг ашиглалтад ороход ашиглалтын зардлыг төлөвлөсөн боловч хугацаанаасаа хойшилж тайлант оны эцэст ашиглалтад орсонтой холбоотойгоор хэмнэлт үүссэн.

- Ерөнхий боловсрол арга хэмжээний гүйцэтгэл 84.2 хувийн биелэлттэй байгаа нь сургуулиудын байр ашиглалтын тогтмол зардлыг өндөр төсөвлөсөнтэй холбоотой байна.
- Насан туршийн болон албан бус боловсрол 73.49 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Насан туршийн болон албан бус боловсролын төвийн хичээлийн байр солигдож түрээсийн зардал хэмнэсэнтэй холбоотой байна.
- Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих арга хэмжээ 81.3 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь Жаргалант сумын хоршоо хөгжүүлэх сангийн төлөвлөсөн арга хэмжээний сонгон шалгаруулалтад шаардлага хангасан аж ахуйн нэгжийн хүсэлт ирээгүйтэй холбоотой хэрэгжилт гараагүй нь нөлөөлсөн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс батламж болон Засгийн газрын зарим чиг үүргийн орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилтийг нэгтгэж, хяналт шинжилгээ үнэлгээ хийн, баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлжээ.

#### **БҮЛЭГ 4. ЗАСГИЙН ГАЗРЫН ГАДААДЫН ЗЭЭЛЭЭР ХЭРЭГЖИЖ БУЙ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭ ОН ДАМЖИН ХЭРЭГЖСЭЭР БАЙНА.**

4.1 Орон нутагт зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөг сайжруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.

Гадаадын зээлийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийн өргөтгөл” төслийн зээлийн төлбөрт өмнөх онд 13,621.4 сая төгрөг, тайлант онд 1,225.9 сая төгрөг, нийт 14,842.1 сая төгрөгийг Сангийн яам суутган тооцсон боловч төслийн гүйцэтгэл 98%-тай, улсын комисс хүлээж аваагүй, өмчлөгчийн асуудал одоог хүртэл шийдвэрлэгдээгүй, нийт зээлийн өр төлбөрийн дүн тодорхойгүй тул урьдчилж гарсан зардлаар тайлагнасаар байна.

Өрийн удирдлагын тухай хуулийн 10.2-т “Аймаг, нийслэлийн Засаг дарга өрийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 10.2.2-д “тухайн орон нутагт зээллэгийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах, үйл ажиллагаанд хяналт тавих” гэж заасны дагуу Төсвийн ерөнхийлөн захирагч нь зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөг сайжруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

4.2 Өмнөх оны Засаг даргын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Өмнөх оны аудитаар 3 зөвлөмж хүргүүлсэн бөгөөд зөвлөмж бүрийг дэлгэрэнгүй авч үзвэл:

- Аймгийн төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч, орлогыг бодитой төлөвлөх, аймгийн Татварын хэлтсийг үр нөлөөтэй ажиллуулах;
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг таслан зогсоох, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгч, үр дүн, гүйцэтгэлийг хэлэлцэж байх;
- Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөг сайжруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх гэсэн зөвлөмжүүдийг өгсөн байна.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн 01/1675 албан бичгээр тайлагнасан боловч Зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөг сайжруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх тухай зөвлөмжийг хэрэгжүүлж, төсөл хариуцсан нэгжтэй уулзалтыг удаа дараа зохион байгуулж, төсөлд зээлийн эргэн төлөгч талаас оролцоог хангаж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэх, санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг таслан зогсоох, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах талаар холбогдох байгууллагуудад чиглэл өгч, үр дүн, гүйцэтгэлийг хэлэлцэж байх гэсэн зөвлөмжийн хүрээнд аймгийн Засаг даргаас аймгийн ИТХ-ын Зөвлөлийн хуралд Хэмнэлтийн тухай хуулийн 7 бүлэг 14 асуудлын хэрэгжилтийг 83%-ийн биелэлттэй гэж дүгнэн, аймгийн ИТХ-ын зөвлөлд тайлагнасан байна.

Аймгийн төлөвлөсөн орлогыг бүрэн төвлөрүүлэхэд анхаарч, орлогыг бодитой төлөвлөх, аймгийн Татварын хэлтсийг үр нөлөөтэй ажиллуулах гэсэн зөвлөмжийн хүрээнд орон нутгийн төсөвт төвлөрөх 2023 оны татварын орлогыг 238,058.1 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 257,455.4 сая төгрөг төвлөрч 19,397.2 сая төгрөгөөр давж биелсэн байх тул зөвлөмжийн хэрэгжилт хангагдсан гэж үзсэн.

Аудитын дүгнэлтүүд:

- Орон нутгийн төсвийн орлогыг 2 удаа тодотгож 36,615.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн татварын орлогод төвлөрөх ёстой орлого Эрдэнэт сангийн орлогоор төлөвлөгдөж байна.
- Төсвийн орлого нийт дүнгээрээ 2.6 хувиар давж биелсэн ч татварын бус орлогын төлөвлөгөө 29 хувиар тасарсан байна.
- Аймгийн татварын бус орлогын төлөвлөгөө 71 хувь буюу 12,140.9 сая төгрөгөөр тасарсан байна.
- Төсвийн зарлагыг бодитой төлөвлөөгүйгээс хэт өндөр хэмнэлт үүсэх, төсвийн зарцуулалтыг байгууллага бүртэй тооцоо нийлж акт үйлдээгүй нь хяналт дутмаг байгааг харуулж байна.
- Нэмэлт санхүүжилтийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.
- Аймгийн 2023 оны худалдан авах ажиллагаанаас 6,325.7 сая төгрөгийн хэмнэлт үүссэн байна.
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн хөтөлбөр, арга, хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэл өмнөх оноос 2.21 хувиар өссөн ч хөрөнгө оруулалтын гүйцэтгэл өмнөх оноос 15 хувиар буурсан байна.
- Орон нутагт зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр нөлөөг сайжруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлээгүй байна.
- Өмнөх оны Засаг даргын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн аудитаар хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

### **Зөвлөмж**

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд зөвлөж байна.

**Аймгийн Засаг даргад:**

- Эрдэнэт сангийн орлогод төлөвлөгдөн батлагдаж буй газрын эрхийн шимтгэлийн орлогыг дуудлага худалдааны дансанд төвлөрүүлж, батлуулж байх.
- Аймгийн Засаг даргын хөтөлбөрөөс олгож буй орон нутгийн нэмэгдлийг оны эцэст төсвийн байгууллага бүрээр тооцоо нийлж баталгаажуулж, үүссэн хэмнэлтийг буцаан орон нутгийн төсөвт төвлөрүүлэх.
- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг бодитой төлөвлөж байх.